



МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГТ ТӨМРИЙН ХҮДРИЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний
хүрээлэнгийн судлаач **Д.Эрдэнэбулган**

2014.05

Монголын төмрийн хүдрийн салбар өндөр зардалтай, хэмжээ нь жижиг, чанар муутай тул өрсөлдөх чадварыг нь бууруулж, хөрөнгө оруулагчдын анхаарлыг татахгүй.



Төмрийн хүдрийн салбарын төлөв байдал

Өнөөгийн байдал

- Монголд нийт **1,250 сая тонн (Fe 25% - 52% агууламжтай)** нөөц бүхий төмрийн хүрдрийн 9 төсөл байдаг.
- Одоогийн байдлаар доод зэргийн (**3.74 сая тонн/жилд**) болон баяжуулсан (**3 сая тонн/жилд**) төмрийн хүдрийг Хятад руу экспортолж байна.
- Ирээдүйд хөрөнгө оруулалт болон санхүүжилтын дутмаг байдлаас шалтгаалан нэмэлт үйлдвэрлэл хязгаарлагдмал болох төлөвтэй.
- Одоогийн дотоодын эрэлт бага байгаа хэдий ч Монголын Засгийн газар түүхий эдийн боловсруулалтыг шатлан хөгжүүлэхэд анхаарлаа хандуулж байна.

Ирээдүйн төлөв байдал


- **Шинээр олборлох үйл ажиллагаа бий болохгүй**
- 2014-2030 оны хооронд одоогийн 9 төсөл **~227.3 сая тн төмрийн хүдэр, ~53.8 сая тн баяжмал** нийлүүлнэ.
- Дэлхийн зах зээлд нийлүүлэлтийн илүүдэл бий болохоос шалтгаалан дунд үе гэхэд төмрийн хүдрийн бүтээгдэхүүний үнэ буурах хандлагатай.
- Одоогийн 9 төслийн **CAPEX** (капиталын зардал)-д **~0.9 тэрбум ам.доллар, 2014-2030** хоорондох нийт **OPEX** (үйл ажиллагааны зардал) нь **~17.9 тэрбум ам.доллар** байна гэж үнэлэгдсэн.



Source: Publically available documents

Монголд нийт 1.250 сая тонн (Fe 25% - 52% агууламжтай) баталгаажсан нөөц бүхий төмрийн хүдрийн 9 төсөл байдаг

Монгол дахь төмрийн хүдрийн үйлдвэрлэл





Агууламжаасаа шалтгаалан төмрийн хүдрийн үнэ бага байгаа тул Оюут-Овоо, Төмөртэйн олборлолтын үйл ажиллагаа түр зуур зогсонги байдалтай байгаа.

Тэмдэглэл: Зөвхөн Сэлэнгийн төсөл богино хугацааны худалдааны гэрээ байгуулсан.

Төмрийн хүдэр нь нүүрс болон алтны дараах Монголын нийт экспорт болон төсвийн 3 дахь том бүрдүүлэгч

Төмрийн хүдрийн салбарын Монголын эдийн засагт оруулах хувь нэмэр



Манай улсын нийт экспорт болон төсвийн орлогод үзүүлэх төмрийн хүдрийн хувь нэмэр нэмэгдсэнтэй холбогдуулан Засгийн газрын зүгээс тус салбарыг стратегийн хувьд чухал ач холбогдолтой салбар хэмээн зарлав.

Хэдийгээр Засгийн газар тус салбарыг стратегийн ач холбогдолтой хэмээн үзэж, цаашид хөгжүүлэх төлөвлөгөөтэй байгаа ч зах зээлийн хандлагатай зөрчилдөж байна.

Зах зээлийн ерөнхий байдал болон Засгийн газрын итгэл үнэмшил


	Түлхүүр сэдвүүд	Дүгнэлт
Стратегийн бүтээгдэхүүн	Монголын Засгийн газар 34 хүртэлх хувь эзэмшинэ. Гэвч, бодит байдал дээр хараахан биелээгүй.	Ихэнх компаниудын эзэмшил манай хөрш Хятад улсынх учраас Үндэсний үзэл санаа, түүнд тавих анхаарал өндөр байдаг.
Бүтээгдэхүүн бий болгох үйл ажиллагаа	Дарханы 2.5 сая тоннын хүчин чадалтай төмрийн хүдрийн баяжуулах үйлвэрийг барихад 400 сая төгрөг шаардлагатай. Монголдоо нэмүү өртөг бий болгох зорилгоор үүнтэй адилхан баяжуулах үйлвэрийг Сайншандын аж үйлдвэрийн цогцолборт* барих төлөвлөгөөтэй байна.	Монголын төмрийн хүдрийн уурхайн ашиглалтын хугацаа богинохон, хүдрийн зах зээлийн үнийн төлөв байдлаас шалтгаалан хөрөнгө оруулагчдад ихээхэн хүндрэл авчрахаар байна.
Байгаль орчны асуудлууд	Байгаль орчин, нийгэм болон нийгэмлэгийн асуудлуудаас шалтгаалан төмрийн хүдрийн үйлдвэрлэгчид олон нийтийн хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч байна. Тухайлбал, хамгийн том үйлвэрлэгч болох Ерөө голын үйл ажиллагаа олон нийтийн эсэргүүцэлтэй тулгарч, зогсонги байдалд орсон.	Идэвхтэй тэлэлтийн төлөвлөгөө Засгийн газар болон олон нийтийн хооронд саналын зөрүүтэй байдал бий болгохоор байна.

Монгол дахь төмрийн хүдрийн уурхайн ашиглалтын богино насжилт хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахад ихээхэн хүндрэл учруулж болзошгүй

* Сайншандын аж үйлдвэрийн цогцолборт 9 боловсруулах үйлдвэр баригдах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд (зэх хайлуулах, хүдэр бутлах болон коксын үйлдвэр) нийт 9 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай. (Чингис бондынхоос 6 дахин их)

Өндөр зардал, бага нөөц, агууламж муутай чанар зэрэг нь Монголын төмрийн хүдрийн салбарын өрсөлдөх чадварт саад болох бөгөөд хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахгүй

Төмрийн хүдрийн хил дээрх үнийн төлөв байдал болон зардал




Дэд бүтцийн хязгаарлагдмал байдал, макро эдийн засгийн эмзэг нөхцөл байдал болон уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтын таатай бус нөхцөлөөс шалтгаалан зардлын оновчлолыг тодорхойлох орон зай хязгаарлагдмал байна

^Нийт 625 сая тонн нөөц бүхий, төмрийн хүдрийн 60 орчим төсөл 2013-2015 онд эхлэхээр төлөвлөгдөж байна. (340 сая тонн нь BHP Billiton, Rio Tinto, Vale and FMG)

Монголын төмрийн хүдрийн үйлдвэрлэгчид 2014-2030 онд ~227 сая тоннын хүдэр, ~54 сая тоннын баяжмал олборлох таамаглалтай байна.

Төмрийн хүдрийн үйлдвэрлэлийн төлөв байдал болон түүний эрэлт (2007-2030)




Олборлолтын эрчимтэй тэлэлт хөрөнгө оруулалтын хувьд боломжтой гэвэл Засгийн газрын зүгээс экспортыг хязгаарлах бодлогоос үл хамааран нөөц эрчимтэйгээр багасах хандлагатай

*Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор

2014-2030 онд олборлолтоо нэмэгдүүлэх, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийн тулд төмрийн хүдрийн салбарт 18.8 тэрбум ам.долларын нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай


Хөрөнгө оруулалтын урьдчилсан нөхцөлүүд



Уурхайн өргөжилт, дэд бүтэц болон баяжуулах үйлдвэрт ~0.9 тэрбум ам.долларын капитал хөрөнгө оруулалт хэрэгтэй. 2014-2030 онд нийт OPEX ~17.9 тэрбум ам.доллар гэж тооцоологдож байна.

^ Нийт хөрөнгө оруулалтын 53% (импортыг тооцохгүйгээр) нь үржүүлэгчийн нөлөөллөөр Монголд үлдэхээр тооцоологдож байна

Хөрөнгө оруулалтын урьдач нөхцөлүүд (2014-2030)



Энэхүү судалгааны нэг зорилго нь төмрийн хүдрийн төслүүдийн Монголын эдийн засагт үзүүлэх шууд бус нөлөөг (Үржүүлэгчийн нөлөөлөл) тооцоолох явдал юм.

^CAPEX (капиталын зардал) болон OPEX (үйл ажиллагааны зардал)

Монгол улсын эдийн засаг дахь төмрийн хүдрийн нөлөөллийг тооцохын тулд хоёр ялгаатай хувилбарыг авч үзлээ.

Хувилбаруудад тавьсан урьдач нөхцөлүүд

Суурь хувилбар:
ТӨМРИЙН ХҮДЭРГҮЙ
(таамаглал)

- Энэхүү загварт төмрийн хүдрээс бусад бүх уул уурхайн төслүүд төлөвлөгөөт үйлдвэрлэлээрээ ажиллана^ (төмрийн хүдэр байхгүй)
- Таваарын үнүүд нь олон хувилбарын дундаж үнэ бөгөөд Монголын хил дээрх үнээр дискоунтлагдсан.
- 2014-2030 онд уул уурхайн салбар дахь нэмэлт гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ төмрийн хүдрийн салбарыг хассан үед 13 тэрбум ам.доллар байна. Үүнд: дулааны эрчим хүчний нүүрс: 1.4 тэрбум, металлургийн нүүрс: 1.2 ам.доллар, зэс: 8.7 тэрбум ам.доллар байна.

Бодлогын хувилбар:
ТӨМРИЙН ХҮДЭРТЭЙ

- 2014-2030 онд суурь хувилбар дахь уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд нэмж 227.3 Мт төмрийн хүдэр, 53.8 Мт төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэгдэнэ.
- Төмрийн хүдрийн үнэ нь олон хувилбарын дундаж үнэ бөгөөд Монголын хил дээрх үнээр дискоунтлагдснаас гадна дунд хугацаандаа буурна.
- 2014-2015 онд ГШХО-аар болон дотоодын хөрөнгө оруулалтаар **0.9 тэрбум ам.доллар** нэмэгдэх бөгөөд 2014-2030 онд 17 тэрбум ам.долларын үйл ажиллагааны зардал гарна.


Бүх тоон үзүүлэлтүүд 2013 оны үнээр илэрхийлэгдсэн ба Доллар/Төгрөгийн ханш 1523

^ОТ-н далд уурхай 2015 онд эхэлнэ гэж нөхцөл тавив

ҮР ДҮН

2014-2030 оны хооронд Эдийн засагт ~31.3 их наяд төгрөгийн (20.8 тэрбум ам.доллар) нөлөөг голчлон уул уурхай, тээвэр болон үйлчилгээний салбаруудаар дамжуулан үзүүлэхээр байна

Бодит ДНБ-д үзүүлэх төмрийн хүдрийн шууд болон шууд бус нөлөөлөл




Шууд бус нөлөөллөөр тээвэр, үйлчилгээний салбар дахь нэмүү өртгийг нэмэгдүүлэх нь төмрийн хүдрийн салбарын түлхүүр юм

Суурь хувилбарт төмрийн хүдрийг тооцоогүй, бодлогын хувилбарт тооцсон болно ^ Үр өгөөж гэдгээр энэ хоёр хувилбарын зөрүүг илэрхийлнэ

Тус салбар нь экспорт болон хөрөнгө оруулалтын дотогшлох урсгалд илүү өндөр өгөөжтэй бөгөөд төгрөгийг чангаруулах нөлөөтэй


Гадаад худалдаа ба ханшид үзүүлэх нөлөө



2014-2030 онд төмрийн хүдрийн экспорт нийт экспортод дунджаар 6%-ийн нөлөөлөл үзүүлнэ

Хөрөнгө оруулалт нь хөдөлмөрийн багтаамж багатай хэдий ч нийт ажиллах хүчний эрэлтийг 4300 ажилчдаар нэмэгдүүлэхээр байна (Цалин үүнтэй зохицож тогтоно)

Цалинд үзүүлэх нөлөө




2014-2030 онд өрхийн орлого 9.4 их наяд төгрөгөөр (6.2 тэрбум ам.доллар) өсөх ба үүний 70 хувь нь хөдөлмөрийн эрэлтээс үүдсэн болно

*Шууд : Төмрийн хүдрийн төслөөс авах ажилчидын цалин болон татвар , Шууд бус: Татвар, ханган нийлүүлэгчдийн ажилчидын цалин, үйлчигээн, худалдааны төлбөр зэрэг

2030 он гэхэд тус салбарын төсөв дэх шууд хувь нэмэр 0.4%-иар буурч, нийт нөлөөлөл 2%-иас илүү байхаар байна.

Улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл (шууд болон шууд бусаар)




2014-2030 онд, Засгийн газрын орлого 13.8 их наяд (9.1 тэрбум ам.доллар) төгрөгөөр нэмэгдэж, хамгийн оргилдоо 2021 онд хүрч, нийт нөлөөлөл нь улсын төсвийн орлогыг 7%-иар нэмэгдүүлэхээр байна.

*Шууд татвар төлөлт: Цалин болон татвар, Шууд бус татвар төлөлт: Татвар болон ханган нийлүүлэгчид, тэгдгээрийн ажилчдын цалин, гадаадаас авах үйлчилгээний өртгийг цалингаар тооцсон

Төмрийн хүдрийн салбар дахь хөрөнгө оруулалт 2014-2030 онд жил бүр 1.2 тэрбум ам.долларын нэмүү өртгийг бий болгоно

Төмрийн хүдрийн эдийн засаг дахь нөлөө




Их наяд төгрөг (2013): Эдийн засагт үзүүлэх нөлөө	Одоогоор: 2013	2030 онд	
		Төмрийн хүдэр байхгүй	Төмрийн хүдэр байгаа
Бодит ДНБ	17.5	70.8	72.4
Хувийн хэрэглээ	8.0	28.3	29.1
Засгийн газрын зардал	2.9	18.4	18.7
Хөрөнгө оруулалт	8.7	20.5	21.2
Экспорт	4.3	16.0	16.2
Импорт	6.4	12.4	12.8
Нийт цалин	8.2	30.8	31.1
Төсвийн орлого	5.9	25.8	26.2

Төмрийн хүдрийн төслөөс орох орлогод тулгуурлан дотоодын ханган нийлүүлэгчид, ажилчид болон Засгийн газрын импортын худалдан авалт


Харьцуулсан дүн шинжилгээ

Төмрийн хүдрийн салбарын хэмжээ нь Монголын бусад уул уурхайн эрдэс баялагтай харьцуулахад бага

Монголын уул уурхайн голлох эрдэс баялгийн хэмжээ



CAPEX (2013, Их наяд төгрөг)




Төмрийн хүдрийн төслүүдэд шаардлагатай CAPEX нь Оюутолгой төслийн 2 дугаар үе шатны хөрөнгө оруулалтын 1/5 –тэй тэнцүү

^ Бөмбөлөгийн хэмжээ нь таамаглаж буй үйлдвэрлэлийн өртөг (2013, Их наяд төгрөг)


2030 он хүртэл экспортын нөлөө нь буурсаар байх ба хугацааны эцэст маш бага хэмжээнд хүрнэ

Уул уурхайн экспорт дахь нөлөөлөл

Уул уурхайн үйл ажиллагааны төслийн тоо^



Эрдэс баялгийн экспорт (2013 их наяд төгрөг)




Ерөө гол зэрэг богино хугацаатай уурхайн үйл ажиллагаа нь 2030 онд зогсох учраас урт хугацаанд төмрийн хүдрийн нөлөөлөл маш бага хэмжээнд хүрнэ.

^ Давхар тоологдоогүй: ОТ –н зөвхөн зэсийн баяжмалыг тооцсон болно

Төмрийн хүдрийн салбарын Монголын эдийн засаг дахь нөлөөлөл нь хамгийн ихдээ 5%-д хүрэх ба энэ нь Оюутолгойн нийт нөлөөллөөс 5 дахин бага хэмжээ юм

Эдийн засаг болон улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл



*Шууд болон шууд бус нөлөөлөл, ^Шууд бус нөлөөллийн татварын орлого тооцогдоогүй

Төмрийн хүдрийн Монголын эдийн засаг дахь нөлөө нь урт хугацаандаа бага хэмжээнд хүрэх ажээ.

Дүгнэлт

Энэ судалгаагаар төмрийн хүдрийн 2014-2030 оны хооронд Монголын эдийн засагт үзүүлэх нөлөөг судлахаар зорьсон.

Одоогийн байдал (2013)

- Төмрийн хүдэр нь Монголын экспорт болон улсын төсөвт **гуравдагч томоохон хувь нэмрийг** болон экспортын орлогын 15%, уул уурхайн төсвийн орлогын 10%, нийт төсвийн орлогын 2%-ийг эзэлнэ.
- **Хөдөлмөрийн зах зээл дэх нөлөөлөл нь бага:** 4300 ажилчин нэмэгдэх ба нийт цалингийн орлогын 0.4%-ийг л бүрдүүлнэ
- Төмрийн хүдрийн **ДНБ дэх шууд нөлөө нь 2%**, шууд бус нөлөөлөл болон нэмэлт ажлын байрыг оруулан тооцвол **ДНБ-ийн 3.5%-д** хүрнэ


Ирээдүйн хандлага (2014-2030)

- 2030 он хүртэл **экспортын нөлөө нь буурсаар байх** ба хугацааны эцэст маш бага хэмжээнд хүрнэ. (2030 онд нийт экспортын 0.8%)
- Төмрийн хүдрийн хөрөнгө оруулалт **дотоодын нийт үйлдвэрлэлд харьцангуй бага хэмжээний хувь нэмэр үзүүлнэ** (ДНБ-ийн 4% бөгөөд 2014-2030 онд жил бүр 1.2 тэрбум ам.долларын нөлөө үзүүлнэ)
- Төмрийн хүдрийн салбарын Монголын эдийн засаг дахь нөлөөлөл нь олон томоохон төслүүдийн зөвхөн нэгнийх нь хэмжээнээс бага **нөлөөтэй:** Энэ салбар эдийн засагт хамгийн ихдээ 5%-д хүрэх ба энэ нь “Оюутолгой”-н нийт нөлөөллөөс 5 дахин бага хэмжээ юм.

Хавсралт

Үйлдвэрлэлийн эрчимтэй өргөжилтөөс үл хамааран уурхайн ашиглалтын богино насжилтаас шалтгаалан Сайншандын * нөөц дутагдал бий болох хандлагатай (Ирээдүйд)

Монголын төмрийн хүдрийн үйлдвэрлэл 2020 онд (Сая тонн/жилд)



*Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор